



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"ХЭЛЭЛЦСЭН нь: "Дахин төлөвлөлтийн тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч дахин үнэлгээнд хамрагдсан, сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 3,100,874,890.00 (гурван тэрбум нэг зуун сая найман зуун далан дөрвөн мянга найман зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 736,593,521.76 (долоон зуун гучин зургаан сая таван зуун ерэн гурван мянга таван зуун хорин нэгэн төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий барилга нь газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй, зарим бүтээц хийцүүд хэсэгчлэн аваарын байдалд байгаа нь Барилгын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тухай Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2021 оны 01-07-020/42 дугаар дүгнэлт, Барилгын хөгжлийн төвийн барилгын материалын сорилт шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторийн 2021 оны 0000034, 0000035 дугаар сорилт, шинжилгээний дүн, Хот байгуулалт, хөгжлийн газрын барилгад хийсэн хэмжилт, судалгааны дүгнэлтээр тус тус нотлогдож байна.

Азийн хөгжлийн банкны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд хандив тусламжаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төвийн асуудлыг цогцоор нь шийдсэн орчин үеийн шийдэл бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төв"-ийн 8 давхар барилга барих зорилгоор ашиглалтын шаардлага хангахгүй байгаа дээрх объектыг дахин төлөвлөлтөд хамруулах тухай хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5 байршилд шинэ барилга барих зорилгоор 1 дүгээр төвийн барилгыг дахин төлөвлөлтөд оруулах асуудлыг дэмжих нь зүйтэй гэж үзэв" гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

